

ТАНГАРАГИЙН ЗАГВАР / Эм зүйчийн андгай

Эм зүйч би эмийн мэргэжилтний баримтлах зарчим, үүрэг хариуцлагыг ухамсарлан хүн амын эрүүл мэндийн төлөө үйлчилэхээ андгайлж байна.

- Би хүнлэг чанарыг эрхэмлэж хүн төрөлхтний сайн сайхны төлөө хамгийн өндөр стандартыг удирдлага болгож ажиллана.
- Би өдөр тутмын үйл ажиллагаандаа хүн амын сайн сайхан, эрүүл мэндийг дэмжиж ажиллахын тулд өөрийн мэдлэг, чадвараа бүрэн дайчилна.
- Би хэрэглэгчдэд үзүүлж байгаа бүхий л үйлчилгээндээ өөрийн ашиг сонирхол, хувийн бусад асуудлаа тунгаан хэрэгцээг нь тогтоож байна.
- Би үйлчилгээндээ шударга, адил тэгш байдлыг дээдлэн үйлчлүүлэгчийн нас, хүйс, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, соёл, улс төрийн итгэл үнэмшилд хүндэтгэлтэй хандана.
- Би үйлчлүүлэгчийн хувийн болон эрүүл мэндийн мэдээллийн нууцлалыг чанд хамгаална.
- Би мэргэжлээрээ тасралтгүй хөгжиж дэвшиж мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай байна.
- Би эм зүйн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ мэргэжлийн мэдлэг, стандартыг хөгжүүлж ажиллана.
- Би мэргэжлийн залгамж чанарыг эрхэмлэж хойч үеэ халамжлан хүмүүжүүлнэ.
- Би эмнэлгийн мэргэжилтнүүдтэй хамтын ажиллагаагаа хөгжүүлэх бүхий л боломжийг ашиглана.

Эм зүйчийн үүргээ хэрэгжүүлэхэд бүх хүчээ дайчлан тангаргаа хэзээ ч зөрчихгүй ажиллана гэдгээ энэ ариун тангаргийг өргөн андгайлж байна.

Эм зүйч:

Гарын үсэг:

Он сар өдөр: